



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.05.16 № 01/8550.
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР
ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид гаргахгүй байх таслан зогсоох, арилгах арга хэмжээг авах ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн авто замын газар, нийслэлийн 6 дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн төлөөллийг оролцуулан тулгарч буй асуудлаар “Явган замын хавтан, авто замын хашлагын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулав.

Нийслэл, дүүрэг болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоогүйгээс Улаанбаатар хотын хэмжээнд явган хүний замын хавтан, авто замын хашлага хийхэд нэгдсэн нэг төлөвлөлтгүй, стандарт загвараар төлөвлөж гүйцэтгэдэггүй, зураг төсөл хийгдээгүй ажлыг тендер сонгон шалгаруулалтад оруулдаг, ашиглагдаж буй явган замын хавтангийн үйлдвэрлэлт, гүйцэтгэлд чанар, стандартын шаардлага хангагдаж буй эсэхэд зохих хяналт тавьдаггүйгээс ашиглалтын хугацаа багатай материалаар ажил гүйцэтгэдэг, эвдрэл гэмтлийн судалгаа хийгээгүйгээс явган хүний зам талбайг жил дараалан сольж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зэрэг асуудлуудыг хэлэлцүүлгийн явцад хөндөж, зайлшгүй ойрын хугацаанд үүнийг засаж шийдвэрлэх ёстой гэсэн дүгнэлтэд оролцогчид санал нэгтэй хүрлээ.

Иймд дээрх асуудлаар Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” гэж заасны дагуу албан “Зөвлөмж”-ийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох байгууллагууд зохих арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2023 оны 08 дугаар сарын 15-ны дотор хариуг ирүүлнэ үү.

Хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөгөө мэдээллийг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс авч, хамтран ажиллана уу.

Хувийг: Барилгын хөгжлийн төв, Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ, Нийслэлийн замын хөгжлийн газар, Нийслэлийн хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн 9 дүүрэг, Зам тээврийн хөгжлийн төвд.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА



142303008775

Авлигатай тэмцэх газрын
2023 оны 05 дугаар сарын 16 -ны өдрийн
..01/.. дугаар албан бичгийн хавсралт
/8550.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Нийслэл хотод шинээр баригдах явган хүний замын төлөвлөлтийг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт хөгжлийн газар хариуцаж, дүүрэг болон бусад байгууллага төлөвлөлтөд тусгахаар санал хүргүүлэх, төлөвлөгөөнд тусгагдаагүй зураг, төсөл хийгдээгүй ажлыг тендер сонгон шалгаруулалтад оруулахгүй байх.

Нийслэлийн хэмжээнд авто замын хашлага, явган замын хавтан барих ажлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийслэлийн 9 дүүрэг улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, Улсын Их Хурлын гишүүний тойрогтоо хийх ажлын төсвийн ангиллаас гарах зэрэг санхүүжилтийн олон эх үүсвэрээр судалгаа төлөвлөгөөгүй, давхцуулан, жил дараалан эвдэрч гэмтээгүй замыг солих зэргээр харилцан уялдаагүй ажиллаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгааг хэлэлцүүлэгч оролцогч нар онцолсон.

Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Баянзүрх дүүргийн 6,15,18,25,26 дугаар хорооны нутаг дэвсгэрт явган зам, ногоон байгууламж барих түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээг 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр “Люксдаймонд” ХХК-тай 945,864,547 төгрөгийн дүнтэй гүйцэтгэсэн байна. Гэрээнд засвар шинэчлэлтийн ажлын хугацааг 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 14-ний хооронд хийж гүйцэтгэхээр заасан ч уг хугацаандаа хийж гүйцэтгээгүй, олон нийтийн социал сүлжээгээр “өмнөх жил нь сольсон явган хүний зам, аж ахуйн нэгжүүдийн өөрсдийн хөрөнгөөр хийсэн зам талбайг хуулан авч дахин сольж байгаа нь төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулж байна, хүүхдийн хичээлийн шинэ жил эхэлж байхад түгжрэл үүсгэж хийж байна” гэх шүүмжлэл ирсний дагуу АТГ-аас шалгалтын ажил зохион байгуулахад судалгаа шинжилгээ зураг, төсөлгүй явган замын хавтан, авто замын хашлагыг солих ажлыг хийсэн, Нийслэл, дүүрэг харилцан уялдаа холбоогүй ажилласнаас жил дараалан нэг газарт бүтээн байгуулалтын ажлыг давтан хийсэн байна.

Иймд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасныг үндэслэж Нийслэл хотод шинээр баригдах явган хүний зам болон бусад тохижилтын ажил хийхээс өмнө Хот байгуулалт хөгжлийн газраас санал авч ажиллах нь зүйтэй байна.

Зөвлөмж 2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартыг дахин судалж, стандартыг шинэчлэх салбарын байгууллагуудад стандартын талаар нэгдсэн нэг ойлголттой болох.

Монгол улсад явган хүний зам, талбайн төлөвлөлттэй холбоотой MNS:6808 2019 стандарт нь явган хүний зам, талбайн төлөвлөлт техникийн шаардлагыг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталж 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрөөс мөрдөж эхэлсэн гэтэл Нийслэлийн Засаг Даргын Хэрэгжүүлэгч Агентлаг Хотын стандарт, хяналтын газраас UCS0901B:2022 стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2022 оны 21-р тогтоолоор Явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлагыг давхардуулан гаргасан байна. Уг стандартуудыг захиалагч байгууллагууд өөрсдийн дураар сонгож ажлын

даалгаврыг боловсруулж байгаагаас явган хүний зам, талбайн төлөвлөлт, гүйцэтгэл хийх, хүлээж авах шатанд салбарын байгууллагуудад хүндрэл бэрхшээлийн үүсгэж, үл ойлголцол бий болж, зураг төслийн зохиох шатнаас ойлгомжгүй нөхцөл байдал бий болж байна. Тухайлбал, MNS:6808 стандартыг баримталж зураг төслийг зохиосон байхад хяналт тавьж, хүлээж авах комисс UCS0901B:2022 стандартыг баримталж хүлээн авч байгаа нь явган хүний зам, талбайн бүтээн байгуулалтын ажлын чанарт нөлөөлөх хүчин зүйл болж байна. MNS:6808 стандартад мэргэжлийн зөвлөх компани хяналтаа тавьдаг бол Нийслэлийн авто замын газар UCS0901B:2022 стандартыг баримталж технологийн хяналтыг “хяналтын инженер” гүйцэтгэдэг.

Зөвлөмж 3. Авто зам, явган замд тухай бүр засвар, арчилгааг чанартай хийж гүйцэтгэх.

“Улаанбаатар хот тохижилт ОНӨААТҮГ” нь ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, тохижуулалт, цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлт, нийтийн эзэмшлийн гудамж, **автозам, явган зам, талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилт, хөшөө дурсгалын цогцолбор газрын засвар, арчлалт** зэргийг чиг үүргийн хүрээнд хариуцан хийдэг хэдий ч эвдэрч гэмтсэн зам талбайг тухай бүр засварлалт хийх мэргэжлийн боловсон хүчин, баг байхгүй. Харин эвдэрч гэмтсэн талбайг тухайн жилд бүртгэн авч, тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах замаар бусдаар гүйцэтгүүлэх ажлыг хийж байна. Энэ нь нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн эвдрэлийг тухай бүр цаг алдалгүй засах, нөхөн засварлалт хийх боломжгүй, мэргэжлийн бус тоног төхөөрөмжтэй “би чадна” гэдэг ажлын туршлагагүй хүмүүсээр ажил гүйцэтгүүлдэг асуудлыг цэгцлэх санал гарсан. Цаашид “засварын шуурхай дуудлагын бригад” байгуулан дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

Зөвлөмж 4. Гүйцэтгэлийн чанарын захиалагчийн хяналтыг сайжруулах, ажил хүлээн авахад олон нийтийн хяналтыг нэвтрүүлэх.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос явган хүний зам барихад гүйцэтгэгч тал зураг төслийн дагуу хийгддэггүй, материалын чанар шаардлага хангадаггүй, гүйцэтгэлийн чанарын хяналт одоог хүртэл байхгүй явж ирсэн талаар оролцогч талууд санал нэгдсэн.

Тухайлбал, Сүүлийн жилүүдэд явган зам барих зураг төсөлд ус зайлуулах хоолой, хөтөч хавтан, унадаг дугуйн зам, авто замын хашлагын налууг гарц хооронд хийхээр тусгагдсан байдаг боловч бодит байдалд аль аль нь хийгдээгүй эсвэл зураг төсөлд тусгагдсанаас өөр тэгш бус гадаргуутай, чанаргүй, хэлбэр хэмжээ өөрчлөгдсөн байдаг зэрэг асуудлыг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын “Зам барилгын эрдэм шинжилгээ, судалгааны итгэмжлэгдсэн лаборатори”, Техник технологийн дээд сургуулийн “Барилга замын материал судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-оос ирсэн төлөөлөгчид шүүмжлэлтэй хандаж, цаашид зураг төсөл боловсруулах, ажлын даалгавар боловсруулж тендер сонгон шалгаруулалт зохион байгуулах, явцын гүйцэтгэлд захиалагч тал өдөр бүр хяналт тавих, ажлыг хүлээж авах комисс хариуцлагатай ажиллах зэргээр бүх шатны хяналтыг сайжруулах хэрэгтэй, хяналт сул тавьсан албан тушаалтнуудад хариуцлага тооцож байх шаардлагатай талаар ярилцсан.

Мөн олон улсын жишгээр нийтийн эзэмшлийн тохижилт, явган хүний зам, хүүхдийн тоглоомын талбайг хүлээн авахад тухайн бүс нутаг дэвсгэрт амьдран суух иргэдийн төлөөллийг хүлээн авах комисст оруулах замаар олон нийтийн хяналтыг нэвтрүүлэх санал гаргав.

Зөвлөмж 5. Өмнө нь баригдсан болон шинээр баригдсан явган хүний зам, авто замын хашлагын үнэлгээг гаргаж, өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах, шинэчлэлтийн ажлын хүрээнд хуучин замыг шинэ материалаар солих

тохиолдолд эвдэрч гэмтээгүй хавтан, материалыг бүртгэн авч засвар шинэчлэлт, нөхөн засварлалт хийхэд ашиглаж байх.

Нийтийн өмчийн зам талбайн үнэлгээг гаргах, явган замын хавтан, авто замын хашлага бүрийн үнийг тодорхойлж, эзэнжүүлэх ажил хийгдээгүйгээс Улаанбаатар хотод эвдэрч, гэмтсэн нийтийн эзэмшлийн талбай, явган хүний замыг хариуцах эзэнгүй, хохирлыг нөхөн төлүүлэх ажил хийгдэхгүй байгаа талаар хэлэлцүүлэгт оролцогчид онцлов. Цаашид эд хөрөнгийн үнэлгээ хийгдэж, зам талбайг эзэнжүүлснээр түүний арчлалт, хамгаалалт сайжрах зэргээр төсвийн хөрөнгөд хэмнэлт үүсэх боломж бүрдэх олон давуу тал үүсэх зэрэг саналыг дэвшүүлсэн.

Мөн хэлэлцүүлгийн үеэр эвдэрч гэмтээгүй явган замын хавтанг дахин ашиглах боломжтой байтал Хот тохижилтын байгууллага болон бусад төрийн байгууллагуудад хүлээлгэн өгч, эвдэрч гэмтсэн өөр газарт нөхөн засварлалт хийхэд ашигладаггүй зэргээр шүүмжлэлүүд гарав. Хэлэлцүүлэг зохион байгуулагчдын зүгээс эвдэрч гэмтээгүй хавтангуудыг хаана хүлээлгэн өгдөг талаар тодруулахад гүйцэтгэгч компанийн төлөөллүүд хог дээр хаях эсвэл захиалагч талын аль нэг даргад хүлээлгэн өгдөг зэрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудлуудыг ярьсан. Цаашид явган хүний замд хэсэгчлэн нөхөн засварлалт хийх ажлыг нэвтрүүлснээр эвдэрч, гэмтээгүй явган замыг хуулж, шинэ хавтан солих зэргээр төсвийн хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулах нөхцөл байдал арилна, эвдэрч гэмтээгүй замын материал гарсан тохиолдолд бүртгэн авч, нөхөн засварлалт хийхэд ашиглах нь зөв гэж дүгнэсэн.

Зөвлөмж 6. Нийслэл, дүүргийн хэмжээнд явган замын хавтан, авто замын хашлагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн байдалд сүүлийн 3 жилийн байдлаар судалгаа, дүн шинжилгээг хийж, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлэх.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт “Нийслэл хотын хөгжлийн түүх, хэтийн төлөв, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны талаар тулгамдаж байгаа асуудлыг судлах чиг үүрэг бүхий судалгаа, шинжилгээний төв Нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллана” гэж заасныг үндэслэн Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна. Үүнд:

Явган замын хавтан, авто замын хашлагын төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байршил, төсөвт өртөг, гүйцэтгэлийн тоон мэдээлэл.

Явган замын хавтан, авто замын хашлагын ажил гүйцэтгэх шаардлагатай байршлын талаар тооцоо, судалгаа хийх.

Явган замын хавтан, авто замын хашлагын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн төлөвлөлт Нийслэл, дүүрэгт төлөвлөж байгаа нөхцөл байдалд тус тус дүн шинжилгээ хийх ажлыг уялдуулан зохион байгуулж үр дүнг холбогдох байгууллагуудад мэдээлэх.

Зөвлөмж 7. Ажлыг хангалтгүй гүйцэтгэдэг, хариуцлагагүй аж ахуйн нэгжүүдийн талаар “ажлын гүйцэтгэлийн түүх” үүсгэж тендерт өрсөлдөх байдлын шалгуур үзүүлэлтэд оруулах, стандартын шаардлага хангаагүй явган зам, тохижилтын ажил гүйцэтгэж улсад хохирол учруулсан нь 3 шатны шүүхээр тогтоогдсон компаниудыг Сангийн яамны хар жагсаалтад оруулах.

Авлигатай тэмцэх газраас нийтийн эзэмшлийн тайлбай, явган зам барих, авто замын хашлага солих барилгын ажлыг гурав бөгөөд түүнээс дээш удаа гэрээний хугацаа хэтрүүлж ажил гүйцэтгэсэн, гүйцэтгэл хангалтгүй, хүлээлгэн өгсөн ажил нь

их засвар хийхээс өмнө эвдэрч гэмтсэн, авлигын гэмт хэрэг, шударга бус өрсөлдөөний тухай хууль зөрчсөн талаар шүүхийн шийдвэр гарсан, ажил гүйцэтгэх явцдаа төрд хохирол учруулсан зэрэг 4 зөрчлийг гаргасан тохиолдолд “Ажил гүйцэтгэлийн түүх”-ийг шинээр үүсгэж, тендер сонгон шалгаруулах үзүүлэлтэд оруулах санал гаргаж, хэлэлцүүлэгт оролцогч нарт танилцуулсан билээ. Хэлэлцүүлэгт оролцогч нарын зүгээс “Ажил гүйцэтгэлийн түүх” үүсгэх саналыг боломжтой гэж үзэн дэмжсэн.

Зөвлөмж 8. Тохирлын гэрчилгээ олгогдсон явган замын хавтан, авто замын хашлага үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний чанарт лабораторийн шинжилгээг тогтмол хийх, хяналтыг сайжруулах.

Хавтан, хашлагын үйлдвэрлэл, явган хүний замын хавтан, авто замын хашлагын материалд ашиглагдаж буй материалын чанарын стандартын шаардлага үйл ажиллагаанд хяналт тавих олон улсын стандартын дагуу хэрэгжүүлж байгаа чулуун хавтанг хэрэгжүүлэх боломжтойг судлах шаардлагатай талаар хэлэлцүүлэгт оролцогч нар санал илэрхийлсэн.

Тухайлбал, Барилга хөгжлийн төвөөс шаардлага хангасан аж ахуй нэгж байгууллагад “Тохирлын гэрчилгээ”-г гаргуулан өгдөг. Гэвч тус газар нь “Зам талбайн хучилтын бетон” гэх техникийн шаардлагыг тавьдаг хэрнэ үйлдвэрлэлийн явцын хяналт байхгүйгээс явган замын шинэчлэлт, засвар, ачлалтын хийх үед хавтан цохилтын хүчийг даалгүй хагарч, гэмтэж, нэг жил хүрэхгүй хугацаанд эвдрэл гэмтэл гардаг асуудлууд байна. Тус гэмтлийг Авто замын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дүгээр зүйлийг “Авто замын арчлалт, урсгал болон ээлжит засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тухайн замыг хариуцагч байгууллага гүйцэтгэнэ” үндэслэж тухай төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн компанид захиалагч талаас шаардлага тавихад гүйцэтгэгч компани тохирлын гэрчилгээтэй хавтан үйлдвэрлэгч компанитай баталгааны маргаан үүсгэж дахин засдаггүйгээс болж жил дараалан сольж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна.

Иймд Барилгын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 зааныг үндэслэж төсөл арга хэмжээнүүдийн ажлын даалгаварт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө явган замын хавтан, авто замын хашлаганд заавал лабораторийн дүгнэлт авч гэх байхаар тусгах.